

**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ, СУНГАЛТЫН УЛСЫН ТЭМДЭГТИЙН
ХУРААМЖ**

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

35.2.1.согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн суманд 1 000 000 төгрөг, бусад суманд 500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн суманд 300 000 төгрөг, бусад суманд 200 000 төгрөг;

35.2.2.11.00-22.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн суманд 500 000 төгрөг, бусад суманд 300 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн суманд 300 000 төгрөг, бусад суманд 100 000 төгрөг;

35.2.3.14.00-04.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуулийн 35.2.2-т заасан хэмжээнээс гурав дахин нэмэгдүүлэн тооцно.

35.4.Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

Р.Энхтуул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа
үйлчилгээ, аялал жуулчлалын бодлого хариуцсан
ахлах мэргэжилтэн)
Холбоо барих утас: 99051683